



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 02.

Бор-Өндөр

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Сумын Онцгой комиссын хуралдаан 2025 оны 03 сарын 25-ны өдрийн 17:00 цагт Засаг даргын Тамгын газрын ажлын байрны Иргэний танхимд 81,8 хувийн ирцтэй эхлэв.

Хуралдааныг Бор-Өндөр сумын Онцгой комиссын дарга даргалж, холбогдох асуудлыг хэлэлцэв.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1. Цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах тухай
2. Аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийн бэлтгэл ажлын талаар хэлэлцэх тухай
3. Сумын Онцгой комиссын 2025 оны 03 сарын 13-ны өдрийн 1 дүгээр хуралдаанаар Шуурхай штабт өгсөн чиглэлийн дагуу хийсэн ажлын мэдээлэл сонсох
4. Аймгийн Засаг даргын 2025 оны 01 тоот албан даалгаврын хүрээнд Хаврын хуурайшилтын улирал эхэлсэнтэй холбогдуулан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажил болон бэлэн байдлын үзлэгтэй холбогдон гарах зардлыг сумын гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэх тухай

СОНССОН НЬ:

1. Сумын Онцгой комиссын 2025 оны 03 сарын 13-ны өдрийн 1 дүгээр хуралдаанаар Шуурхай штабт өгсөн үүрэг, чиглэлийн дагуу хэрэгжүүлсэн ажил, аймгийн Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэгийн бэлтгэл ажлын талаар Шуурхай штабын даргын мэдээллийг сонсоё.

Онцгой комиссын дарга Г.Адъяабилэгт

2. Аймгийн Засаг даргын 2025 оны 01 тоот албан даалгавар мөн 2025 оны 03 сарын 17-ны өдрийн А/136 дугаар Захирамжийн дагуу сумын байнгын ажиллагаатай шуурхай штаб хуралдаж 6 шуурхай баг томилон ажиллуулж байна.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хийж буй ажлын явц 1-4 дүгээр баг 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Хөдөөгийн 5, 6 дугаар баг 70 хувийн гүйцэтгэлтэй явж байна. Уг ажилтай холбогдон гарах зардлыг сумын Онцгой комисст хүргүүлсэн.

Аймгийн Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэгтэй холбогдуулан сумын Онцгой комиссын даргын 2025 оны 01 дүгээр Тушаалаар сумын Шуурхай штабын бүрэлдэхүүнийг нөхөн томилгоожуулж шинэчлэн байгуулсан. Техник, багаж тоног төхөөрөмж, баримт бичгийн бүрдэл, гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийсэн.

Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрээс бусад албан байгууллага, аж ахуйн нэгжүүд томилгоот бүрэлдэхүүнд албан хаагчдаа томилж нэрсийн жагсаалтыг ирүүлсэн.

Сумын ерөнхий, болон тусгай зориулалттай Мэргэжлийн ангид томилгоожсон албан хаагчдыг дуудсан цагт бэлэн байлгах зохион байгуулалтын ажлыг албан байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагууд хариуцах

Монгол улсын Засгийн газрын 20217 оны 67 дугаар тогтоолын дагуу 2025 оны 03 сарын 27-ны өдрийн 16:00 цагаас Газар хөдлөлтийн аюулыг таниулах, зарлан мэдээллийн дохиогоор цугларахад анхаарч ажиллах

Онцгой комиссын гишүүн, Засаг даргын орлогч, шуурхай штабын дарга Х.Галбадрах

3. Сумын Онцгой комиссын хуралдаан зарлахад зар мэдээлэл аваад ирдэггүй гишүүд байна. Өнөөдрийн хуралдааны товыг утсаар болон цахимаар мэдэгдсэн боловч УБТЗ-ын харъяа Бор-Өндөр төмөр замын өртөөний дарга, УБТЗ-ын харъяа замын 3 дугаар ангийн 11 дүгээр хэсгийн дарга, "ЦДҮС" ТӨХК-ны ЗӨБС-ын Бор-Өндөр дэд станцын инженер нар ирээгүй бөгөөд энэ асуудал удаа дараа давтагдаж байгаа тул Бор-Өндөр сум дахь Онцгой байдлын хэлтсийн дарга, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, дэд хурандаа Г.Мөнхнаран дээрх гишүүдийн хариуцлагагүй байдалд холбогдох арга хэмжээ авч ажиллах

Монголросцветмет ТӨҮГ-ын харъяа Бор-Өндөр УБҮ-ийн захиралын хувьд Монголросцветмет ТӨҮГ-ын удирдлагууд тус суманд ажилллаж байгаа тул хуралдаанд оролцох боломжгүй байгаа талаар мэдэгдсэн.

Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх ажил болон аймгийн Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэгийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 3 156 000 /гурван сая нэг зуун тавин зургаан мянга/ төгрөгийг гамшгийн эрсдлийг бууруулах сангаас зарцуулах

**Онцгой комиссын гишүүн, нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга
З.Ууганжаргал**

4. Цаг агаарын урьдчилсан мэдээгээр ойрын 3 хоногт нойтон цас орж, хүчтэй салхилах төлөвтэй байгаа тул Онцгой комиссын гишүүд байгууллагын барилга байгууламжийн аюулгүй байдал дээр анхаарч ажиллах

Шуурхай штаб сумын ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийг шаардлагатай тохиолдолд бэлэн байлгах

Албан байгууллага, аж ахуйн нэгжүүд байгууллагын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөндөө тодотгол хийж хянуулах

Онцгой комиссын орлогч дарга, дэд хурандаа Г.Мөнхнаран

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Онцгой комиссын гишүүн, Засаг даргын орлогч, шуурхай штабын дарга Х.Галбадрахад:

1.1. Тусгай болон ерөнхий зориулалттай Мэргэжлийн ангийн томилгоотой холбогдуулан холбогдох албан байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагуудад танилцуулж, бүрэлдэхүүнийг яаралтай бэлэн байлгах

1.2. Монгол улсын Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоол, 2011 оны 339, 340 дүгээр тогтоолын дагуу Газар хөдлөлтийн аюулыг таниулах, зарлан мэдээллийн дохиогоор цугларах дадлага сургуульд 2025 оны 03 сарын 27-ны өдрийн 16:00 цагт бүх нийтээр хамрагдах ажлыг зохион байгуулахыг багийн Засаг дарга, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд албан бичгээр хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

1.3. Шуурхай штабын бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж, цаг агаар хүндэрсэн нөхцөлд сумын ерөнхий зориулалттай мэргэжлийн анги болон томилгоот техникийг болзошгүй дуудлага, аврах ажиллагаанд бэлэн байх

Хоёр. Онцгой комиссын гишүүн, нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга 3.Ууганжаргалд:

2.1. Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх ажил болон аймгийн Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэгийн бэлтгэл хангах ажлын хүрээнд зарцуулагдах 3 156 000 /гурван сая нэг зуун тавин зургаан мянга/ төгрөгийг зардал тус бүрээр нарийвчлан тооцож, сумын гамшгийн эрсдлийг бууруулах сангаас зарцуулах Захирамж төлөвлөж, санхүүжилт хийх

Гурав. Онцгой комиссын орлогч дарга, дэд хурандаа Г.Мөнхнаранд:

3.1. Сумын Онцгой комиссын үйл ажиллагаанд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж оролцдоггүй онцгой комиссын гишүүн УБТЗ-ын харъяа Бор-Өндөр төмөр замын өртөөний дарга, УБТЗ-ын харъяа замын 3 дугаар ангийн 11 дүгээр хэсгийн дарга, "ЦДҮС" ТӨХК-ны ЗӨБС-ын Бор-Өндөр дэд станцын инженер нарт албан бичгээр мэдэгдэл хүргүүлж, хувийг дээд шатны байгууллагад хүргүүлэх арга хэмжээ авч холбогдох зөрчилд хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцож ажиллах

Хуралдаан 18:00 цагт дуусав.

СУМЫН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА

ГАДЪЯАБИЛЭГТ

СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА БӨГӨӨД
ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

3.УУГАНЖАРГАЛ